



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2024/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум 2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг:[erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 цахим хаяг:[tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг:[ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг:  
[b\\_myadagmaa@yahoo.com](mailto:b_myadagmaa@yahoo.com)

Аудитор Д.Оюундаваа

Утас 99389692 Цахим хаяг: [Oyuna\\_60@yahoo.com](mailto:Oyuna_60@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsগুল@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/251  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ ТӨВ  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ц.НАЦАГДОРЖ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 50 хувь буюу 22,714.6 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Аудитын гол асуудал

Шинэ мөрөн худалдааны төв ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 62,394.9 мянган төгрөгийн залруулга хийж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5 зөвлөмж өгсөн.

#### Бусад асуудлын хэсэг

Шинэ мөрөн худалдааны төв ХХК нь 2023 оны зорилтот түвшний орлогыг 103.2 хувь биелүүлж, зардлыг төлөвлөсөн хэмжээнээс 8 хувиар хэмнэж ажилласан байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

9724040606

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	106,838,228.57	149,119,684.62
1.1.2	Дансны авлага	43,231,665.68	65,946,258.21
1.1.6	Бараа материал	27,457,323.62	26,988,362.83
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>177,527,217.87</b>	<b>242,054,305.66</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,544,739,319.16	5,362,452,137.33
1.2.2	Биет бус хөрөнгө	96,250,000.00	104,050,000.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,640,989,319.16</b>	<b>5,466,502,137.33</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,818,516,537.03</b>	<b>5,708,556,442.99</b>
2.1.1.1	Дансны өглөг	14,076,764.37	3,934,437.41
2.1.1.2	Цалингийн өглөг	1,487,118.15	722,933.31
2.1.1.3	Татварын өр	7,010,004.01	20,282,118.18
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	104,298.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	331,100.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>22,573,886.52</b>	<b>25,374,886.90</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>22,573,886.52</b>	<b>25,374,886.90</b>
2.3.1	Өмч: - төрийн	5,461,000,000.00	5,468,800,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	804,442,672.00	804,442,672.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(469,500,021.50)	(590,061,115.91)
2.3.11	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,795,942,650.50</b>	<b>5,675,381,556.09</b>
2.4	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,818,516,537.03</b>	<b>5,708,556,442.99</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	561,655,693.55	616,166,264.44
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>561,655,693.55</b>	<b>616,166,264.44</b>
	<b>Нийт зардал</b>	<b>641,998,288.68</b>	<b>690,220,045.96</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	641,952,488.68	689,969,253.96
11	Санхүүгийн зардал	45,800.00	250,792.00
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>0,00</b>	<b>(9,724,053.03)</b>
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(9,724,053.03)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(80,342,595.13)</b>	<b>(83,777,834.55)</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(80,342,595.13)</b>	<b>(83,777,834.55)</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>(80,342,595.13)</b>	<b>(83,777,834.55)</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
----------	-----	---------------------------------	-----------------------	----------

<b>2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл</b>	5,461,000,000.00	804,442,672.00	(389,157,426.38)	5,876,285,245.62
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(80,342,595.13)	(80,342,595.13)
<b>2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	5,461,000,000.00	804,442,672.00	(469,500,021.51)	5,795,942,650.49
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(36,783,259.85)	(36,783,259.85)
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	0.00	0.00	(83,777,834.55)	(83,777,834.55)
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	5,461,000,000.00	804,442,672.00	(590,061,115.91)	5,675,381,556.09

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
6	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	535,468,269.09	623,203,101.86
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	483,543,941.00	614,087,791.86
	Бусад мөнгөн орлого	51,924,328.09	9,115,310.00
1.2	Мөнгөн зарлага (-)	478,416,268.55	560,744,331.23
	Ажиллагчдад төлсөн	205,849,816.35	236,618,143.90
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	23,757,505.16	53,697,093.33
	Бараа материал худалдан авахад төлсөн	62,124,450.00	67,820,615.00
	Ашиглалтын зардалд төлсөн	115,828,374.43	137,587,385.94
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,233,000.00	9,500,300.00
	Татварын байгууллагад төлсөн	57,605,122.61	48,774,793.06
	Даатгалын төлбөрт төлсөн	5,146,000.00	5,146,000.00
	Бусад мөнгөн зарлага	872,000.00	1,600,000.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>57,052,000.54</b>	<b>62,458,770.63</b>
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,299,680.00	20,300,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,299,680.00	20,300,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,299,680.00)	(20,300,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	41,752,320.54	42,158,770.63
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>65,085,908.03</b>	<b>106,841,569.99</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>106,838,228.57</b>	<b>149,119,684.62</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны төлөвлөгөө	2023 оны гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Гүйцэтгэлийн хувь
I	<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>596,392,200.00</b>	<b>616,166,264.44</b>	19,774,064.44	<b>103%</b>
1	Худалдааны төвийн орлого	556,522,200.00	585,453,682.44	28,931,482.44	105%
2	50*100* Цогцолборын орлого	19,000,000.00	10,839,272.00	-8,160,728.00	57%
3	Соёмбо Цогцолборын орлого	8,370,000.00	10,758,000.00	2,388,000.00	129%
4	Бусад орлого	12,500,000.00	9,115,310.00	-3,384,690.00	73%
	<b>Нийт үйл ажиллагааны зардал</b>	<b>747,592,406.40</b>	<b>690,220,045.96</b>	-57,372,360.44	<b>92%</b>
11	Нийт цалингийн зардал	227,774,640.00	213,193,533.00	-14,581,107.00	94%
1	НД-ын шимтгэл	30,749,576.40	25,939,322.00	-4,810,254.40	84%
2	ТУЗ-н зардал	43,734,540.00	41,710,410.16	-2,024,129.84	95%
3	Томилолтын зардал	10,480,000.00	8,590,000.00	-1,890,000.00	82%
4	Цахилгаан эрчим хүчний зардал	91,579,730.00	85,353,423.58	-6,226,306.42	93%
5	Дулаан эрчим хүчний зардал	36,800,000.00	32,600,668.18	-4,199,331.82	89%
6	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	11,313,920.00	6,452,730.52	-4,861,189.48	57%
7	Шуудан холбооны зардал	4,320,000.00	3,547,343.00	-772,657.00	82%
8	Ариутгалын зардал	4,290,000.00	3,251,090.90	-1,038,909.10	76%
9	Бохир ус тээврийн зардал	17,220,000.00	16,376,372.73	-843,627.27	95%
10	Хог хаягдлын зардал	4,760,000.00	2,495,544.00	-2,264,456.00	52%
11	Автомашин, шатахууны зардал	10,700,000.00	10,093,000.01	-606,999.99	94%
12	Бичиг хэргийн зардал	8,724,000.00	4,111,729.00	-4,612,271.00	47%
13	Сургалтын зардал	1,250,000.00	1,004,545.45	-245,454.55	80%
14	Маркетингийн зардал	6,800,000.00	3,796,545.45	-3,003,454.55	56%
15	Аудит төлбөр	2,500,000.00	2,100,000.00	-400,000.00	84%
16	Хөдөлмөр хамгааллын зардал	6,784,000.00	5,898,000.00	-886,000.00	87%
17	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал Нийгмийн хамгааллын зардал	10,394,000.00	16,791,223.00	6,397,223.00	162%
18	Самбар байрлуулсаны газрын төлбөр	500,000.00	480,000.00	-20,000.00	96%
19	Засварын зардал	11,275,000.00	13,130,514.54	1,855,514.54	116%
20	Үндсэн хөрөнгийн элэгдэл	182,749,000.00	178,473,989.34	-4,275,010.66	98%
21	Даатгалын зардал	5,146,000.00	5,146,000.00	0.00	100%
22	Газрын төлбөр	2,000,000.00	1,576,836.00	-423,164.00	79%
23	50*100-н цогцолборын зардал	8,608,000.00	3,864,225.10	-4,743,774.90	45%
24	Соёмбо цогцолборын зардал	7,140,000.00	4,243,000.00	-2,897,000.00	59%

	Үйл ажиллагааны ашиг/ алдагдал/	-151,200,206.40	-74,053,781.46	-77,146,424.94	
	Үйл ажиллагааны бус зардал	-	-9,724,053.03	-	
25	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз (гарз)		-9,724,053.03	-9,724,053.03	
26	Татварын өмнөх ашиг/ алдагдал	-151,200,206.40	-83,777,834.55	67,422,371.85	55%

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 95,974.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 62,394.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, санхүүгийн тайлангийн аудитаар 80.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж нийцлийн аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой 33,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдлөө.

Нийт санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 80.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,191.2 мянган төгрөгөөр бага тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### Залруулсан алдаа:

Аудитын байгууллагад 2024 оны 2 дугаар сарын 15-нд ирүүлсэн санхүүгийн тайлан дараах зүйлүүдээр зөрүүтэй байна.

- Цахилгааны зардал, цэвэр бохир усны зардал, холбооны зардалд НӨАТ суутган тооцож байгаа боловч НӨАТ-тай үнээр зардалд бүртгэж 10,945.8 мянган төгрөгөөр зардлыг нэмэгдүүлж бүртгэсэн.
- ТУЗ-ийн цалин НДШ -ийг гарт олгосон цалингаар 11,706.7 мянган төгрөгөөр дутуу тооцож зардалд бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 13,935.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолж зардалд бүртгэсэн.
- Санхүүгийн тайланд татварын өглөгийг 17,724.9 мянган төгрөгөөр буруу тайлагнасан
- Уурын зуухны 390.м.кв 7800.0 мянган төгрөгийн газрыг биет бус хөрөнгөөр бүртгээгүй
- Санхүүгийн тайлангийн нийт 62,112.4 мянган төгрөгийн залруулга аудитын хугацаанд хийгдсэн болно.
- Аудитын хугацаанд 282.5 мянган төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосныг байгууллагын дансанд буцаан тушаалгалаа.

#### 3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### 3.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

#### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Компаний эзэмшилд байгаа Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт байршилтай 50-100 цогцолборын газрын гэрээ гэрчилгээ, кадастрын эрх зүйн баримт бичгийн бүрдэл дутуу

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заалт болон иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн эзэмшил газрын талаар холбогдох газарт хандаж бичиг баримтын бүрдэл дутуу материалыг бүрдүүлж баримтжуулах

**2.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт

Засвар үйлчилгээ хийлгэсэн ажлын хөлс 80.0 мянган төгрөгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалт болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт журам зааврыг мөрдөж ажиллах

**3.Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт

ТУЗ-өөр батлуулсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй, худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгалаагүй байна.

Тайлант онд 15,000.0 мянган төгрөгийн нүүрс, 18,500.0 мянган төгрөгийн Прусс 30 хуучин авто машиныг хувь хүнээс шууд худалдан авсан нь Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 33.1."Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан "Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах" болон нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах

**4.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт

Тус компаний 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 16 нэр төрлийн 38,943.2 мянган төгрөгийн анхны үнэ бүхий хөрөнгө бүртгэгдэн ашиглагдаж байгаа нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1. "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" заалттай нийцээгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.Программ хангамжтай холбоотой**Илрүүлэлт

Тус компанийн ашиглаж байгаа Санхүүгийн тооцоолох төвийн LEADER программ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын зөвшөөрсөн программ хангамжийн жагсаалтад бүртгэлгүй байна.

Өгсөн зөвлөмж

Байгууллагын онцлогт тохирсон Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын зөвшөөрөлтэй программ хангамж ашиглах

**6.Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайлангийн талаар.**Илрүүлэлт:

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайлан бэлтгээгүй, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан” Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай” журмын 2.1“Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан” (цаашид “тайлан” гэх) нь А-Ё хэсгээс бүрдэнэ” заалт болон нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. .

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын дагуу татварын зөрүүгийн тайлан бэлтгэх Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулга	1	62,112.4			1	62,112.4	1	62,112.4				
Хоолны мөнгө давхар тооцсон	1	282.5			1	282.5	1	282.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>62,394.9</b>			<b>2</b>	<b>62,394.9</b>	<b>2</b>	<b>62,394.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

		/мянган төгрөгөөр/ Үүнээс	
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажлын хөлсийг буруу бүртгэсэн	1	80.0					1	80.0				
50-100 цогцолборын газрын холбогдох баримтгүй	1	0					1	0				
Үндсэн хөрөнгийн ашиглалтийн хугацаа	1	0					1	0				
Программ хангамж	1	0					1	0				
Татварын зөрүүгийн тайлан гаргаагүй	1						1	0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>80.0</b>					<b>5</b>	<b>80.0</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
ТБОНӨХБАУХА тухай хуулийн хэрэгжилт	1	33,500.0					1	33,500.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>33,500.00</b>					<b>1</b>	<b>33,500.00</b>

